| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | 1,013,189,150.00 | 935,895,677.62 | 77,293,472.38   | 92.37  |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | 1,013,189,150.00 | 935,895,677.62 | 77,293,472.38   | 92.37  |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | 961,558,450.00   | 886,734,053.62 | 74,824,396.38   | 92.22  |
| <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 605,211,300.00   | 605,195,810.36 | 15,489.64       | 100.00 |
| Үндсэн цалин  | 442,585,400.00   | 344,728,316.94 | 97,857,083.06   | 77.89  |
| Нэмэгдэл  | 70,543,700.00    | 161,801,483.00 | (91,257,783.00) | 229.36 |
| Унаа хоолны хөнгөлөлт                                 | 47,213,200.00    | 53,812,500.00  | (6,599,300.00)  | 113.98 |
| Урамшуулал  | 44,869,000.00    | 44,853,510.42  | 15,489.58       | 99.97  |
| <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 89,600,700.00    | 89,600,700.00  | 0.00            | 100.00 |
| Тэтгэврийн даатгал                                    | 62,328,600.00    | 62,328,600.00  | 0.00            | 100.00 |
| Тэтгэмжийн даатгал                                    | 5,568,000.00     | 5,568,000.00   | 0.00            | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал                                     | 2,784,000.00     | 2,784,000.00   | 0.00            | 100.00 |

**Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|  |                |                |               |        |
|--|----------------|----------------|---------------|--------|
| Ажилгүйдлийн даатгал   | 2,784,000.00   | 2,784,900.00   | (900.00)      | 100.03 |
| Эрүүл мэндийн даатгал  | 16,136,100.00  | 16,135,200.00  | 900.00        | 99.99  |
| <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 40,579,400.00  | 35,017,696.26  | 5,561,703.74  | 86.29  |
| Гэрэл, цахилгаан   | 7,256,200.00   | 5,922,812.13   | 1,333,387.87  | 81.62  |
| Түлш, халаалт  | 26,619,500.00  | 22,929,184.13  | 3,690,315.87  | 86.14  |
| Цэвэр, бохир ус  | 6,703,700.00   | 6,165,700.00   | 538,000.00    | 91.97  |
| <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 30,333,800.00  | 14,815,899.00  | 15,517,901.00 | 48.84  |
| Бичиг хэрэг  | 4,986,500.00   | 3,130,700.00   | 1,855,800.00  | 62.78  |
| Тээвэр, шатахуун   | 15,500,000.00  | 8,000,000.00   | 7,500,000.00  | 51.61  |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 4,192,800.00   | 2,867,700.00   | 1,325,100.00  | 68.40  |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 2,257,500.00   | 0.00           | 2,257,500.00  | -      |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 3,397,000.00   | 817,499.00     | 2,579,501.00  | 24.07  |
| <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 8,045,900.00   | 5,575,750.00   | 2,470,150.00  | 69.30  |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 895,900.00     | 0.00           | 895,900.00    | -      |
| Урсгал засвар  | 7,150,000.00   | 5,575,750.00   | 1,574,250.00  | 77.98  |
| <b>Томилолт, зочны зардал</b>  | 16,500,000.00  | 9,045,000.00   | 7,455,000.00  | 54.82  |
| Дотоод албан томилолт  | 16,500,000.00  | 9,045,000.00   | 7,455,000.00  | 54.82  |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 44,917,350.00  | 4,368,198.00   | 40,549,152.00 | 9.72   |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,113,650.00  | 4,008,400.00   | 29,105,250.00 | 12.10  |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 89,600.00      | 0.00           | 89,600.00     | -      |
| Даатгалын үйлчилгээ  | 895,900.00     | 0.00           | 895,900.00    | -      |
| Тээврийн хэрэгслийн татвар   | 1,261,300.00   | 0.00           | 1,261,300.00  | -      |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 197,100.00     | 0.00           | 197,100.00    | -      |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 9,000,000.00   | 0.00           | 9,000,000.00  | -      |
| Газрын төлбөр  | 359,800.00     | 359,798.00     | 2.00          | 100.00 |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 126,370,000.00 | 123,115,000.00 | 3,255,000.00  | 97.42  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 126,000,000.00 | 123,115,000.00 | 2,885,000.00  | 97.71  |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 370,000.00     | 0.00           | 370,000.00    | -      |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 51,630,700.00  | 49,161,624.00  | 2,469,076.00  | 95.22  |
| <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 51,630,700.00  | 49,161,624.00  | 2,469,076.00  | 95.22  |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 49,930,700.00  | 49,161,624.00  | 769,076.00    | 98.46  |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 1,700,000.00   | 0.00           | 1,700,000.00  | -      |
| <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                              | 22             | 19             | 3             | 86.36  |
| Төсвийн байгууллага  | 1              | 1              | 0             | 100.00 |
| <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>   | 22             | 19             | 3             | 86.36  |
| Удирдах ажилтан  | 1              | 1              | 0             | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан  | 18             | 15             | 3             | 83.33  |
| Үйлчлэх ажилтан  | 3              | 3              | 0             | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт  | Гүйцэтгэл            |
|------------|---|----------------------|
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                      |
| I          | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>63,060,386.11</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>63,060,386.11</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 63,060,386.11        |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 21,202,875.00        |
| 210102     | Нэмэгдэл  | 21,202,875.00        |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 3,634,000.00         |
| 210402     | Тээвэр, шатахуун  | 3,634,000.00         |
| 2107       | <b>Томилолт, зочны зардал</b>   | 5,177,511.11         |
| 210702     | Дотоод албан томилолт   | 5,177,511.11         |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 33,046,000.00        |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 33,046,000.00        |
| II         | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | 63,060,386.11        |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 63,060,386.11        |
| 131103     | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,088,875.11        |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 971,511.00           |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.00                 |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | 0.00                 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаарх төр, засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, малчид, тариаланчид, иргэдийг мэдээ, мэдээлэл, мэргэжил, арга зүй, технологийн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэж, орон нутгийн болон салбарын түвшинд дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх зорилгод хүрэхэд оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлвэрийн яам болон Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас тус байгууллагад хяналт, шалгалт хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

БНА-2026/118/НА-СТА-ТШЗ



Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,841,845.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 158,296.7 мянган төгрөг буюу 9.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт          |
|--|--------------------|--------------------|-------------------|
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>             | <b>298,191.8</b>   | <b>277,153.5</b>   | <b>(21,038.3)</b> |
| Авлага                                     | 99.2               | 896.0              | 796.8             |
| Бараа материал                             | 298,092.7          | 276,257.5          | (21,835.2)        |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>         | <b>1,385,356.7</b> | <b>1,564,691.8</b> | <b>179,335.1</b>  |
| Үндсэн хөрөнгө                             | 1,963,998.4        | 2,192,748.5        | 228,750.0         |
| Хуримтлагдсан элэгдэл                      | (578,641.7)        | (628,056.7)        | (49,415.0)        |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                  | <b>1,683,548.6</b> | <b>1,841,845.3</b> | <b>158,296.7</b>  |
| Өр төлбөр                                  | -                  | 15,766.4           | 15,766.4          |
| Засгийн газрын хувь оролцоо                | 1,683,548.6        | 1,826,078.9        | 142,530.4         |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> | <b>1,683,548.6</b> | <b>1,841,845.3</b> | <b>158,296.7</b>  |

Авлага дансны үлдэгдэл 896.0 мянган төгрөг нь тайлант онд ногооны үр борлуулсны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 276,257.5 мянган төгрөг болж 21,835.2 мянган төгрөгөөр буурсан байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/05 дугаар тогтоолоор 64,039.7 мянга, албан хаагчдаас 2,049.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, 2025 оны тооллогын комиссын гишүүд, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, байгууллагын даргын тушаалыг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон 51,866.3 мянган

төгрөгийн 98 нэр төрлийн бараа материалыг акталж, данснаас хасаж, тусгай зориулалтын материалын данснаас 20,000.0 мянган төгрөгийн ямааны саалтуурыг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 41,616.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 61,187.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,192,748.5 мянган төгрөг болж 207,711.7 мянган төгрөгөөр өссөн нь 15,955.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ХХААХҮЯ-наас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/374 дугаар тушаалаар, 274,952.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/05 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй хүлээн авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 329 дугаар тогтоолоор 6,081.9 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг дахин үнэлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 456 дугаар тогтоолоор 11,202.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,780.0 мянган төгрөгийн программ хангамж, 31,515.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,650.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын -ний өдрийн 329 дугаар тогтоолоор 19,091.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,766.4 мянган төгрөг нь тайлант оны санхүүжилт батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгогдоогүйгээс үүссэн өглөг байна. Тухайлбал, Бичиг хэргийн зардалд 4,986.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 3,130.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 784.5 мянган төгрөгийн өглөг, тээвэр шатахууны зардалд 15,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,000.0 төгрөгийн санхүүжилт орж, 1,852.0 мянган төгрөгийн өглөг, албан томилолтын зардалд 16,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 9,045.0 мянган төгрөгийн санхүүжилт орж, 6,975.0 мянган төгрөгийн томилолтын өглөг, шуудан холбоо интернэтийн зардалд 4,192.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,867.7 мянган төгрөгийн санхүүжилт орж, 852.2 төгрөгийн өглөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 3,397.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 817.5 мянган төгрөгийн санхүүжилт орж, 670.3 мянган төгрөгийн өглөг, авто тээврийн хэрэгслийн албан татварын 468.4 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,377,169.9 мянган төгрөг болж 142,530.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 142,530.4 мянган төгрөгтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,060,423.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,060.423.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,234.2 мянган төгрөгөөр бууруулж 1,013,189.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,013,189.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 941,474.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 71,714.7 мянган төгрөгийн санхүүжилт аваагүй байна. Гүйцэтгэлээр 935,895.7 мянган төгрөгийг зарцуулж, 5,578.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 935,895.7 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь байр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 15,489.6 мянга, хангамж бараа материалын зардал 15,517.9 мянга, томилолт зочны зардал 7,455.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 40,549.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,255.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| № | Хөтөлбөр, арга хэмжээ                                 | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл  | /мянган төгрөгөөр/ |       |
|---|---|--------------|------------|--------------------|-------|
|   |   |              |            | Зөрүү              | Хувь  |
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал                   | 928,444.80   | 882,725.65 | 45,719.15          | 95.08 |
| 2 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,                   | 51,630.70    | 49,161.62  | 2,469.08           | 95.22 |
| 3 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 33,113.70    | 4,008.40   | 29,105.30          | 12.10 |
|   | Нийт дүн  | 1,013,189.20 | 935,895.68 | 77,293.52          | 92.37 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь 2018 оноос хойш “Хас эрин орчил” ХХК-ны 2,600.0 мянган төгрөгийн Динамик санхүүгийн программ хангамж, “ЛУЭ” ХХК-ийн 1,400.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн тооцооллын программийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын хоол, унааны зардалд 47,213.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр өдрийн 10.0 мянган төгрөгөөр тооцон 53,812.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгож, батлагдсан төсвөөс 6,599.3 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой тайлант оны 11 дүгээр сард цалингийн сан хүрэхгүй цалин дутуу олгосон байсан бөгөөд 12 дугаар сард дутуу олгосон цалинг хоолны хөнгөлөлтөөс олгосон байна.

Тус байгууллагын сургалт семинар зөвлөгөөнд зарцуулахаар 5 арга хэмжээний 17,733.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2 арга хэмжээнд 1,965.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 19, үйлчлэх 4 албан тушаалтны орон тоог баталсан бөгөөд угтах үйлчилгээний ажилтны 1 орон тоог цомхотгосон байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 971.5 мянган төгрөгийг бэлчээр усан хангамжийн гэрээт ажлын хяналтын зардалд, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 63,373.5 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн нэмэгдэл, дотоод албан томилолт, тээвэр шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид нийт 63,060.4 мянган төгрөгийн зарцуулж, орон нутгийн төсөвт 1,284.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Эрхэмбаяр зурж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Уянга нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн батлагдсан төсөвт зардал 941,474.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,414.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,119.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаcт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 996,108.9 мянган төгрөгийн 16 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 198,549.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 61,469.4 мянган төгрөгийн 13 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж аудитаар 17,096.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 1/247 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |          | Биелэлт |          |      |
|-----------------|------------------------|----------|---------|----------|------|
|                 | Тоо                    | Дүн      | Тоо     | Дүн      | Хувь |
| Албан шаардлага | 2                      | 17,096.0 | 2       | 17,096.0 | 100% |
| Нийт дүн        | 2                      | 17,096.0 | 2       | 17,096.0 | 100% |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд 1,013,189.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч гүйцэтгэлээр 941,474.5 мянган төгрөгийн санхүүжилт орж, 71,714.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой 15,775.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Үүссэн өр төлбөрийг 2026 оны төсөвт багтаан барагдуулах талаар анхаарах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 алдаа, зөрчил<sup>1</sup> илэрсэнд алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 5.1 Зөвлөмж

5.1.1 Байгууллагын нэр дээр бүртгэлтэй 4 авто машины тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах хугацаа дууссан байхад техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаагүй байна.

Энэ нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх "Тээврийн хэрэгслийг эзэмшигч Монгол Улсад бүртгэлтэй механикжсан тээврийн хэрэгслийг ашиглалтын явцад тогтоосон хугацаанд

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
 техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид байгууллагын нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хугацаанд нь техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулж, алдааг дахин давтахгүй байх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |     |          |          |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|
|  |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн      |
| Байгууллагын нэр дээр бүртгэлтэй 4 авто машины тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах хугацаа дууссан байхад техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдаагүй байна. | 1           | -        |               |     |                 |     | 1        | -        |
| <b>Нийт дүн</b>  | <b>1</b>    | <b>-</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>-</b> |

-----oOo-----